

ОЛОН УЛСЫН ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГА ҮҮСГЭН БАЙГУУЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ

Удиртгал

Энэхүү Конвенцын оролцогч улсууд,

Эвлэрүүлэн зуучлал нь энх тайван, хөгжлийг дэмжих, улс хоорондын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд чухал үнэ цэнтэй болохыг хүлээн зөвшөөрч,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тусгагдсан зорилго, зарчмуудыг удирдлага болгож,

Олон улсын маргааныг шийдвэрлэхэд уян хатан байх, эвлэрүүлэн зуучлалын чухал давуу тал, практик хэрэглээ улам бүр нэмэгдэж буйг хүлээн зөвшөөрч,

Олон улсын нийгэмлэгийн хувьд маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх байнгын засгийн газар хоорондын байгууллага байгуулах чухал болохыг харгалзан,

Олон улсын Эвлэрүүлэн зуучлалын байгууллагыг ирээдүйд байгуулах тухай Хамтарсан мэдэгдэл нь эвлэрүүлэн зуучлалын олон улсын байгууллага байгуулах чухал алхам болсныг эргэн санаж,

Эвлэрүүлэн зуучлалын олон улсын байгууллага байгуулагдсанаар олон улсын маргааныг энх тайван, эвтэй байдлаар шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, харилцан ашигтай олон улсын харилцааг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулна гэдэгт итгэж,

Эвлэрүүлэн зуучлалын олон улсын байгууллага байгуулагдсанаар эвлэрүүлэн зуучлалын хэрэглээг дэмжин хөгжүүлж, одоо байгаа олон улсын маргаан шийдвэрлэх механизмуудад нэмэлт арга хэрэгсэл болно гэдэгт итгэж,

Аль ч хэлэлцэн тохирогч улс энэхүү Конвенцыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу түүнд нэгдэн орсон гэдэг нь зөвхөн тэр баримтаар, мөн түүний зөвшөөрөлгүйгээр, ямар нэгэн тодорхой маргааныг эвлэрүүлэн зуучлалд өгөх үүрэг хүлээсэн гэж үзэхгүй гэдгийг дахин нотлон,

Дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров:



I БҮЛЭГ

ОЛОН УЛСЫН ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫГ БАЙГУУЛАХ

1 дүгээр зүйл. Байгуулах

Олон улсын эвлэрүүлэн зуучлалын байгууллага (цаашид “Байгууллага” гэх)-ыг үүгээр байгуулж, энэхүү Конвенцын заалтын дагуу үйл ажиллагааг явуулна.

2 дугаар зүйл. Нэр томьёоны тодорхойлолт

Энэхүү Конвенцын зорилгод:

а/“Эвлэрүүлэн зуучлал” гэж нэг буюу хэд хэдэн гуравдагч талууд (эвлэрүүлэн зуучлагч) маргаанд оролцогч талуудад хөндлөнгөөс нөлөө үзүүлэхгүйгээр тэдгээрийн маргааныг сайн дурын үндсэн дээр харилцан хүлээн зөвшөөрөхүйц, эвийн журмаар шийдвэрлэхийг, чингэхдээ энэхүү үйл явцыг эвлэрүүлэн зуучлан, эвлэрүүлэх буюу үүнтэй төстэй бусад хэллэгээр нэрлэх боломжтой.

б/“Хэлэлцэн тохирогч улс” гэж энэхүү Конвенцыг заавал биелүүлэхээ зөвшөөрсөн, мөн тэдгээрийн хувьд Конвенц хүчин төгөлдөр байгаа улсыг хэлнэ;

в/“Хэлэлцэн тохирогч бус улс” гэж энэхүү Конвенц хүчин төгөлдөр болоогүй байгаа улсыг хэлнэ;

г/“Талууд” гэж маргааны бүх талыг, “тал” гэж тэдгээрийн аль нэгийг хэлнэ;

д/“Гуравдагч улс” гэж бусад улсаас Байгууллагад шилжүүлсэн маргаанд холбогдсон улсыг хэлнэ;

е/“Олон улсын байгууллага” гэж Засгийн газар хоорондын байгууллагыг хэлнэ.

3 дугаар зүйл. Зорилго ба зорилт

Байгууллагын зорилго ба зорилт нь эвлэрүүлэн зуучлалаар дамжуулан олон улсын маргааныг энх тайван замаар шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, хөхиүлэн дэмжих, улс хоорондын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино.

4 дүгээр зүйл. Байгууллагын зарчим

Байгууллага болон түүний Хэлэлцэн тохирогч улсууд 3 дугаар зүйлд заасан зорилтыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмуудыг баримтлан ажиллана:



а/бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, тэгш байдлыг хүндэтгэх, улс гүрний дотоод хэрэгт үл оролцох, олон улсын эрх зүйн хууль дээдлэх ёсыг баримтлах;

б/талуудын маргаан шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох бүрэн эрх, сонголтыг баталгаажуулах;

в/олон улсын маргааныг эвийн журмаар шийдвэрлэхэд шударга байх зарчим, үр дүнтэй хамтын ажиллагааг баримтлах;

г/эвлэрүүлэн зуучлалаар дамжуулан маргааныг энх тайван замаар шийдвэрлэхэд уян хатан, үр дүнтэй арга замыг дэмжиж, үл ялгаварласан, төвийг сахисан, шударга орчныг бүрдүүлэх.

5 дугаар зүйл. Үүрэг

Байгууллага нь үндсэн зарчмуудын дагуу зорилт, зорилгоо хэрэгжүүлэхдээ дараах үүргийг гүйцэтгэнэ:

а/олон улсын маргааныг шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлэх;

б/маргаан шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлалын хэрэглээг дэмжих, эвлэрүүлэн зуучлалын соёлыг хөгжүүлэх, эвлэрүүлэн зуучлалын шилдэг туршлагыг судлан дэмжих;

в/эвлэрүүлэн зуучлалын чиглэлээр олон улсын, бүс нутгийн, үндэсний, орон нутгийн арга хэмжээ, бага хурлыг зохион байгуулж, харилцаа холбоо, мэдээлэл солилцох индрийг бүрдүүлэх;

г/эвлэрүүлэн зуучлалын чиглэлээрх чадавхыг бэхжүүлэх хамтын ажиллагааг дэмжихдээ хөгжиж буй орнуудын хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрч, тэргүүнд тавих;

д/ олон улсын бусад байгууллага, маргаан шийдвэрлэх байгууллагуудтай хамтран ажиллах, харилцах.

6 дугаар зүйл. Эрх зүйн байдал

1. Байгууллага нь дараах эрх зүйн бүрэн чадамжуудтай байна:

а/гэрээ хэлцэл байгуулах;

б/хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө олж авах, түүнийгээ захиран зарцуулах;



в/ Хууль эрх зүйн арга хэмжээ авах, үүнд шүүхийн болон бусад хууль эрх зүйн ажиллагааг эхлүүлэх, мөн тэдгээрт хариу өгөх; болон

г/зорилго, үүргээ хэрэгжүүлэхэд хэрэгтэй, эсхүл шаардлагатай бусад арга хэмжээг авах.

2. Байгууллага энэхүү Конвенцод заасны дагуу үүрэг, эрхээ аль ч хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрт, мөн тусдаа хэлэлцээрээр бусад улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж болно.

7 дугаар зүйл. Гишүүнчлэл

1. Байгууллагын гишүүнчлэл нь бүх улс, бүс нутгийн интеграцийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад нээлттэй, хүртээмжтэй байна.
2. "Олон улсын Эвлэрүүлэн зуучлалын байгууллагыг ирээдүйд байгуулах тухай Хамтарсан мэдэгдэл"-д гарын үсэг зурсан, эсхүл уг (Хамтарсан) мэдэгдлийг дэмжсэн улсууд энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн дотор Конвенцыг заавал биелүүлэхээ зөвшөөрвөл Үүсгэн байгуулагч гишүүн болох эрхтэй.
3. Бусад улс энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор Конвенцыг заавал биелүүлэхээ зөвшөөрвөл Үүсгэн байгуулагч гишүүн болох эрхтэй.

8 дугаар зүйл. Төв байр

1. Байгууллагын төв байр нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын засаг захиргааны онцгой бүс болох Хонконг хотод байрлана.
2. Байгууллага шаардлагатай үед бүс нутгийн оффисуудыг бусад газарт байгуулж болно.

9 дүгээр зүйл. Бүтэц

1. Байгууллага нь Удирдах зөвлөл, Нарийн бичгийн дарга нарын газартай байна.
2. Байгууллага нь Эвлэрүүлэн зуучлагч нарын бүрэлдэхүүнийг ажиллуулна.
3. Байгууллага өөрийн зорилго, үүргийг биелүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзвэл туслах буюу зөвлөх хороодыг байгуулж болно.



II БҮЛЭГ

УДИРДАХ ЗӨВЛӨЛ

10 дугаар зүйл. Ерөнхий заалт

Удирдах зөвлөл нь бодлогын шийдвэр гаргах, Байгууллагын ерөнхий стратегийг тогтоох үүрэгтэй шийдвэр гаргах байгууллага болно.

11 дүгээр зүйл. Бүрэлдэхүүн

1. Удирдах зөвлөл нь Хэлэлцэн тохирогч улс бүрийн нэг төлөөлөгчөөс бүрдэнэ. Хэлэлцэн тохирогч улсаас томилогдсон орлох төлөөлөгч нь үндсэн төлөөлөгч нь хуралдаанд оролцох боломжгүй, эсхүл үүргээ гүйцэтгэх боломжгүй тохиолдолд түүний нэрийн өмнөөс төлөөлөгчөөр ажиллаж болно.
2. Удирдах зөвлөл жил бүрийн ээлжит хуралдаанаараа даргыг сонгох бөгөөд дарга нь дараагийн даргыг сонгох хүртэл бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Мөн нэг буюу хэд хэдэн дэд даргыг сонгож болох бөгөөд тэдний бүрэн эрхийн хугацаа нь даргын бүрэн эрхийн хугацаатай адил байна.

12 дугаар зүйл. Эрх мэдэл, чиг үүрэг

1. Энэхүү Конвенцын бусад заалтыг хөндөхгүйгээр, Удирдах зөвлөлд олгогдсон бүрэн эрх, үүргийн хүрээнд Удирдах зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - а/Ажиллах дүрэм, журмаа батлах;
 - б/Байгууллагын захиргаа, санхүүгийн дүрэм, журмыг батлах;
 - в/Ерөнхий нарийн бичгийн дарга, Дэд ерөнхий нарийн бичгийн дарга нарыг сонгон шалгаруулах, томилох журмыг батлах;
 - г/Байгууллагын жилийн орлого, зарлагын төсвийг батлах;
 - д/Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа эхлүүлэх журмыг батлах;
 - е/Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмыг батлах;
 - ж/Эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрмийг батлах;



з/Байгууллагын үйл ажиллагааны жилийн тайланг хянан, батлах;

и/Ерөнхий нарийн бичгийн дарга, Дэд ерөнхий нарийн бичгийн дарга нарыг томилох;

к/Ерөнхий нарийн бичгийн дарга, Дэд ерөнхий нарийн бичгийн дарга нарын ажиллах нөхцөлийг тодорхойлох;

л/Байгууллагын туслах байгууллага, зөвлөх хороодыг байгуулах.

2. Удирдах зөвлөл нь энэхүү Конвенцын заалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн бусад бүрэн эрхийг хэрэгжүүлж, үүргийг гүйцэтгэнэ.
3. Удирдах зөвлөл нь энэхүү Конвенцын дагуу явагдаж буй эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй, мөн талуудын эвлэрлийн гэрээ байгуулахад оролцохгүй.

13 дугаар зүйл. Уулзалт

1. Удирдах зөвлөл жил бүр нэг удаа ээлжит уулзалтыг, мөн Удирдах зөвлөлийн шийдвэрээр, эсхүл дарга, эсхүл Ерөнхий нарийн бичгийн дарга, Удирдах зөвлөлийн гурваас доошгүй гишүүний хүсэлтээр бусад уулзалтыг хийнэ.
2. Удирдах зөвлөл өөрөөр тохиролцоогүй бол хуралдаанууд нь Байгууллагын төв байранд болно.
3. Удирдах зөвлөлийн хуралдааны бүрэн бүрэлдэхүүнийг нь гишүүдийн олонх бүрдүүлнэ.
4. Удирдах зөвлөл гишүүдийнхээ гуравны хоёрын олонхын саналаар гишүүдийг цахим буюу бусад виртуал хэрэгслээр хуралдаанд оролцохыг зөвшөөрч болно.

14 дүгээр зүйл. Шийдвэр гаргах

1. Удирдах зөвлөл аль болох нийтийн зөвшилцлийн үндсэн дээр ажиллана.
2. Хэрэв бүх боломжит арга хэмжээг авсан ч тодорхой асуудлаар зөвшилцөлд хүрч чадахгүй тохиолдолд энэхүү Конвенц, эсхүл Ерөнхий нарийн бичгийн дарга, Дэд ерөнхий нарийн бичгийн дарга нарыг сонгон шалгаруулах, томилох журамд өөрөөр зааснаас бусад тохиолдолд Удирдах зөвлөл уг асуудлын яриа хэлэлцээнд оролцож, санал өгч буй гишүүдийнхээ олонхын саналаар шийдвэрлэнэ. 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн а/ – ж/ болон л/-д заасан шийдвэрийг Удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёрын олонхын саналаар батална.



3. Удирдах зөвлөлийн гишүүн бүр нэг саналтай байна.

III БҮЛЭГ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН ГАЗАР

15 дугаар зүйл. Бүрэлдэхүүн

1. Нарийн бичгийн дарга нарын газар нь Ерөнхий нарийн бичгийн дарга, нэг, эсхүл хэд хэдэн Дэд ерөнхий нарийн бичгийн дарга, мөн шаардлагатай гэж үзсэн бусад албан тушаалтан, ажилтнуудаас бүрдэнэ.
2. Ерөнхий нарийн бичгийн даргыг хэлэлцэн тохирогч улсуудын иргэнээс Удирдах зөвлөл томилно.
3. Нэг буюу хэд хэдэн Дэд ерөнхий нарийн бичгийн даргыг хэлэлцэн тохирогч улсуудын харьяат иргэдээс Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөмжөөр Удирдах зөвлөл томилно.

16 дугаар зүйл. Үүрэг

1. Нарийн бичгийн дарга нарын газар нь Удирдах зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.
2. Нарийн бичгийн дарга нарын газар нь жилийн орлого, зарлагын төсөв, мөн Байгууллагын үйл ажиллагааны жилийн тайланг бэлтгэн, Удирдах зөвлөлөөр хянуулан баталгаажуулна.
3. Нарийн бичгийн дарга нарын газар нь Хэлэлцэн тохирогч улсуудтай харилцах арга хэрэгслийг бий болгоно.

17 дугаар зүйл. Ерөнхий нарийн бичгийн дарга

1. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Байгууллагын хуулийн төлөөлөгч, дээд албан тушаалтан байх бөгөөд энэхүү Конвенцын заалт, Удирдах зөвлөлийн баталсан дүрэм, журмын дагуу албан тушаалтнуудыг томилох зэрэг захиргааны үйл ажиллагааг хариуцна.
2. Ерөнхий нарийн бичгийн даргыг таван жилийн хугацаатай томилох бөгөөд нэг удаа дахин томилогдох эрхтэй.



3. Ерөнхий нарийн бичгийн дарга Удирдах зөвлөлийн хуралдаанд оролцож болох боловч санал өгөх эрхгүй.
4. Ерөнхий нарийн бичгийн дарга нь бүртгэгчийн үүргийг гүйцэтгэх бөгөөд энэхүү Конвенцын дагуу хийгдсэн эвлэрүүлэн зуучлалын тайлан буюу байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах, түүний хуулбарыг гэрчлэх эрхтэй.
5. Ерөнхий нарийн бичгийн дарга нь энэхүү Конвенцын дагуу батлагдсан дүрэм, эсхүл бусад эвлэрүүлэн зуучлалын дүрмийн дагуу, хэрэв эвлэрүүлэн зуучлалын хэлцэл, талуудын дараачийн тохиролцоо, эсхүл бусад заалтад түүнийг томилох этгээдээр заасан бол, томилох этгээдийн үүргийг гүйцэтгэж болно.
6. Ерөнхий нарийн бичгийн дарга нь хэлэлцэн тохирогч улсуудтай харилцах ажлыг удирдаж, олон улсад Байгууллагыг сурталчилна.
7. Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаал нь улс төрийн ямар нэгэн чиг үүргийг гүйцэтгэхгүй. Ерөнхий нарийн бичгийн дарга болон Дэд ерөнхий нарийн бичгийн дарга нарын аль нь ч Удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр өөр ажил эрхлэх, эсхүл өөр мэргэжлийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

18 дугаар зүйл. Олон улсын шинж чанар

1. Ерөнхий нарийн бичгийн дарга, Нарийн бичгийн дарга нарын газрын албан тушаалтнууд болон ажилтнууд үүргээ гүйцэтгэхдээ зөвхөн Байгууллагын өмнө бүрэн хариуцлага хүлээх бөгөөд өөр ямар ч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй.
2. Хэлэлцэн тохирогч улс бүр энэхүү үүргийн олон улсын шинж чанарыг хүндэтгэж, дээрх хүмүүст үүргээ гүйцэтгэхэд нь нөлөөлөх гэсэн аливаа оролдлогоос татгалзах ёстой.



IV БҮЛЭГ

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАГЧДЫН БҮРЭЛДЭХҮҮН

19 дүгээр зүйл. Эвлэрүүлэн зуучлагчдын бүрэлдэхүүнийг байгуулан ажиллуулах


1. Байгууллага нь эвлэрүүлэн зуучлагчдын хоёр бүрэлдэхүүнийг байгуулан ажиллуулна. Үүнд: нэг бүрэлдэхүүн нь 25 дугаар зүйлд заасан маргааныг эвлэрүүлэн зуучлахад (цаашид "улс хоорондын эвлэрүүлэн зуучлагчдын бүрэлдэхүүн" гэх), нөгөө бүрэлдэхүүн нь 27, 28 дугаар зүйлд заасан бусад маргааныг эвлэрүүлэн зуучлах (цаашид "ерөнхий эвлэрүүлэн зуучлагчдын бүрэлдэхүүн" гэх) зорилготой.
2. Бүрэлдэхүүнүүд нь дараах зүйлд заасны дагуу томилогдсон, уг бүрэлдэхүүнд ажиллахад бэлэн байгаа мэргэшсэн хүмүүсээс бүрдэнэ.
3. Байгууллага шаардлагатай гэж үзвэл эвлэрүүлэн зуучлагчдын бусад тусгай бүрэлдэхүүнийг байгуулан ажиллуулж болно.

20 дугаар зүйл. Хэлэлцэн тохирогч улсын томилгоо

1. Хэлэлцэн тохирогч улс бүр өөрийн харьяат иргэдээс тав хүртэлх хүнийг улс хоорондын эвлэрүүлэн зуучлагчдын бүрэлдэхүүнд, мөн өөрийн харьяат иргэдээс хорь хүртэлх хүнийг ерөнхий эвлэрүүлэн зуучлагчдын бүрэлдэхүүнд тус тус томилж болно.
2. Үүсгэн байгуулагч гишүүн бүр өөрийн харьяат иргэдээс арав хүртэлх нэмэлт хүнийг ерөнхий эвлэрүүлэн зуучлагчдын бүрэлдэхүүнд томилж болно.
3. Бүх томилгоог Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх бөгөөд томилгоо нь мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

21 дүгээр зүйл. Мэргэшлийн шаардлага

1. Эвлэрүүлэн зуучлагчдын бүрэлдэхүүнд томилогдох хүмүүс ёс суртахууны өндөр чадамжтай, хууль, худалдаа, аж үйлдвэр, санхүү зэрэг салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, эвлэрүүлэн зуучлал явуулахад мэргэшсэн хүмүүс байна.
2. 1 дэх хэсэгт заасан мэргэшлийн шаардлагаас гадна улс хоорондын эвлэрүүлэн зуучлагчдын бүрэлдэхүүнд томилогдох хүмүүс нь олон улсын эрх зүй, дипломат, олон улсын харилцаа, эсхүл олон улсын улс төр, эдийн засгийн асуудлаар хүлээн зөвшөөрөгдсөн, улс төрийн өргөн хүрээний ур чадвар, дүгнэлт хийх чадамжтай байна.



22 дугаар зүйл. Удирдах зөвлөлийг томилох

1. Удирдах зөвлөл нь улс хоорондын эвлэрүүлэн зуучлагчдын бүрэлдэхүүнд арав хүртэлх хүнийг, ерөнхий эвлэрүүлэн зуучлагчдын бүрэлдэхүүнд хорь хүртэлх хүнийг тус тус томилж болно.
2. Удирдах зөвлөл бүрэлдэхүүнд ажиллах хүмүүсийг томилохдоо 21 дүгээр зүйлийг баримтлахаас гадна, бүрэлдэхүүнд ерөнхий эрх зүйн тогтолцоонуудын төлөөллийг оролцуулах, газар зүйн олон янз байдал, хүйсийн тэнцвэрт байдлыг хангана.

23 дугаар зүйл. Бүрэн эрхийн хугацаа

1. Бүрэлдэхүүнд томилогдсон хүмүүс таван жилийн хугацаатай бөгөөд дахин томилогдож болно.
2. Бүрэлдэхүүнд томилогдсон хүн нас барсан, огцорсон, эсхүл түүний томилгоог эгүүлэн татсан тохиолдолд түүнийг томилсон хэлэлцэн тохирогч улс буюу Удирдах зөвлөл үлдсэн хугацаанд ажиллахаар өөр хүнийг томилох эрхтэй.

V БҮЛЭГ

ХЭРГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

24 дүгээр зүйл. Ерөнхий заалт

1. Байгууллага нь талууд маргаан гарахаас өмнө буюу гарсны дараа харилцан тохиролцож шилжүүлсэн дараах олон улсын маргааныг шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлнэ:

а/улс хоорондын маргаан;

б/улс болон өөр улсын харьяат иргэн хоорондын маргаан;

в/хувь этгээдүүд хоорондын олон улсын арилжааны маргаан.

2. Маргааны нэг тал эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад хэдийд ч өөрийн санаачилгаар зуучлалд өгсөн зөвшөөрлөө эгүүлэн татаж болно, гэхдээ талууд өөрөөр тохиролцсон, эсхүл холбогдох гэрээ буюу хэлэлцээрт өөрөөр заасан тохиолдолд энэ нь хамаарахгүй.



25 дугаар зүйл. Улс хоорондын маргаан

1. Байгууллага хэлэлцэн тохирогч улсуудын хүсэлтээр, маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлэхээр тохиролцсон эрх зүйн маргаан, санал зөрөлдөөн, эсхүл бусад маргаантай асуудлыг шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлнэ.
2. Хэрэв хэлэлцэн тохирогч бус улс, эсхүл олон улсын байгууллага өөрийн маргаанаа Байгууллагад шилжүүлэхийг хүсвэл Байгууллага нь Удирдах зөвлөлөөс баталсан дүрмийг баримтлан тэдгээрт эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлж болно.
3. Байгууллага нь улс тус бүр 29 дүгээр зүйлд заасны дагуу мэдэгдэл хийж, зуучлалд хамруулах боломжгүй гэж мэдэгдсэн маргаан, тухайлбал, нутаг дэвсгэрийн бүрэн эрхт байдал, далайн хил тогтоох, далайн ашиг сонирхол, эсхүл тухайн улс зуучлалд хандах нь тохиромжгүй гэж үзсэн бусад асуудалтай холбоотой маргааныг эвлэрүүлэн зуучлахаас татгалзана.

26 дугаар зүйл. Гуравдагч улсыг хамарсан маргаан

1. Улсуудаас гаргасан маргаанд гуравдагч улс холбогдсон бол холбогдох гуравдагч улсын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр Байгууллага тэрхүү маргаанд эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлэхгүй.
2. 1 дэх хэсгийн зорилгоор маргааны талууд энэхүү Конвенцын дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлүүлэхдээ ийм нөхцөл байдлын талаар Байгууллагад мэдэгдэнэ. Мөн гуравдагч улс энэ талаар Байгууллагад мэдэгдэж болно.

27 дугаар зүйл. Улс болон өөр улсын харьяат иргэн хоорондын маргаан

1. Байгууллага нь хэлэлцэн тохирогч улс болон өөр улсын харьяат иргэний хоорондын арилжааны буюу хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлнэ.
2. Хэрэв талууд маргаанаа Байгууллагад шилжүүлэхийг хүсвэл Байгууллага нь Удирдах зөвлөлийн баталсан нөхцөлийг баримтлан, хэлэлцэн тохирогч бус улс, эсхүл олон улсын байгууллагын оролцоотой арилжааны, эсхүл хөрөнгө оруулалтын маргаанд эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлж болно.



3. Энэхүү Конвенцын зорилгоор улс, эсхүл олон улсын байгууллага гэдэгт тухайн улсаас Байгууллагад томилон мэдэгдсэн улсын бүрэлдэхүүн хэсэг буюу агентлаг, эсхүл олон улсын байгууллагын агентлагийг багтаана.
4. Хэлэлцэн тохирогч улсын бүрэлдэхүүн хэсэг буюу агентлагийн өгсөн зөвшөөрөлд тухайн улсын баталгаажуулалтыг шаардана, гэхдээ тухайн улс Байгууллагад ийм баталгаажуулалт шаардлагагүй гэж мэдэгдсэн тохиолдолд энэ нь хамаарахгүй.
5. Энэхүү Конвенцын зорилгоор харьяат иргэн гэдэгт хувь хүн, эсхүл хуулийн этгээдийг хэлнэ.

28 дугаар зүйл. Хувь этгээдүүд хоорондын олон улсын арилжааны маргаан

1. Байгууллага нь Удирдах зөвлөлийн баталсан нөхцөлийг баримтлан, хувь этгээдүүд хоорондын олон улсын арилжааны харилцаанаас үүдэн гарсан, эсхүл түүнтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлнэ.
2. Хувь этгээдийн аль нэг нь хувь хүний, гэр бүлийн, эсхүл ахуйн зорилгоор хийсэн гүйлгээнээс үүдэн гарсан маргаан нь энэ зүйлийн хамрах хүрээнд орохгүй.
3. Энэхүү Конвенцын зорилгоор хувь этгээд гэдэгт хувь хүн, мөн ашиг олох зорилготой эсэхээс үл хамааран, хувийн, эсхүл төрийн өмчит эсэхийг харгалзахгүйгээр, холбогдох хуулийн дагуу байгуулагдсан буюу зохион байгуулагдсан аж ахуйн нэгж, тухайлбал, корпорац, траст, түншлэл, нэг хүний өмчлөлтэй компани, хамтарсан үйлдвэр, эсхүл бусад нэгдэл, мөн ийм аж ахуйн нэгжийн салбарыг ойлгоно.

29 дүгээр зүйл. Мэдэгдэл

1. Аливаа улс энэхүү Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл түүнд нэгдэн орох үедээ, эсхүл үүнээс хойш хэдийд ч 25, 27 дугаар зүйлд заасан аливаа төрлийн маргаанаа Байгууллагад шилжүүлэх боломжгүй гэж үзэж буй тухайгаа гэрээ хадгалагчид мэдэгдэж болно. Гэрээ хадгалагч энэхүү мэдэгдлийг бүх хэлэлцэн тохирогч улсуудад нэн даруй хүргүүлнэ.
2. Энэхүү мэдэгдэл нь 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шаардагдах зөвшөөрлийг бүрдүүлэхгүй бөгөөд хэлэлцэн тохирогч улс тодорхой маргаанаа тусгайлан зөвшөөрч Байгууллагад шилжүүлэх эрхэд хохирол учруулахгүй.



3. Ийм мэдэгдэлд хэдийд ч нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл эгүүлэн татаж болно.

VI БҮЛЭГ

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

30 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлалын зарчим

Энэхүү Конвенцын дагуу явуулах эвлэрүүлэн зуучлал нь сайн дурын үндсэн дээр, төвийг сахисан, бие даасан, шударга, үр дүнтэй, зардал багатай байх зарчмуудыг баримтлан явагдана.

31 дүгээр зүйл. Хэргийг бүртгэх

1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлүүлэхийг хүсэж буй маргааны талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлүүлэх журмын дагуу Ерөнхий нарийн бичгийн даргад хүсэлт гаргана.
2. Ерөнхий нарийн бичгийн дарга нь тухайн маргаан энэхүү Конвенцын хамрах хүрээнээс гадуур, эсхүл гуравдагч улс холбогдсон боловч тус улсын урьдчилсан зөвшөөрөл аваагүйгээс бусад тохиолдолд хүсэлтийг бүртгэнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга бүртгэсэн, эсхүл бүртгэхээс татгалзсан тухайгаа талуудад нэн даруй мэдэгдэнэ.

32 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлалыг явуулах

1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь энэхүү Конвенцын заалтын дагуу, мөн талууд өөрөөр тохиролцоогүй бол Удирдах зөвлөлийн баталсан эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмын дагуу явагдана.
2. Эвлэрүүлэн зуучлагч нь ашиг сонирхлын зөрчил гарч болзошгүй аливаа нөхцөл байдлыг талуудад ил болгоно.
3. Эвлэрүүлэн зуучлагч нь талуудтай шударгаар харьцах, эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрмийн дагуу талуудын хооронд маргаантай асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэнэ.



33 дугаар зүйл. Нууцлал

Талууд өөрөөр тохиролцоогүй, тухайн мэдээлэл, эсхүл баримт бичиг аль хэдий нь олон нийтэд нээлттэй болсон, эсхүл хуулиар мэдээллийг задруулахыг шаардсанаас (25 дугаар зүйлд заасан маргааныг эс тооцвол) бусад тохиолдолд, энэхүү Конвенцын дагуу явагдаж буй эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай холбоотой бүх мэдээлэл, мөн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад хийгдсэн буюу олж авсан бүх баримт бичгийн нууцлалыг хамгаална.

34 дүгээр зүйл. Бусад ажиллагаанд нотлох баримт болгон оруулах

Талууд өөрөөр тохиролцоогүй бол аль ч тал нь арбитр, шүүх, эсхүл бусад аливаа ажиллагаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад өөр талын илэрхийлсэн үзэл бодол, мэдэгдэл, хүлээн зөвшөөрөх, эвлэрэх санал, эсхүл эвлэрүүлэн зуучлагчийн гаргасан тайлан буюу зөвлөмжийг эш татахгүй.

35 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлагчийн үүргийн хязгаарлалт

Талууд өөрөөр тохиролцоогүй, эсхүл холбогдох хуульд өөрөөр заагаагүй бол эвлэрүүлэн зуучлагч нь маргааны ижил сэдэвтэй холбоотойгоор хянан шийдвэрлэж буй, эсхүл ирээдүйн шүүн таслах, арбитр, эсхүл бусад аливаа ажиллагаанд өөр байдлаар оролцохгүй.

36 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлалыг дуусгавар болгох

1. Дараах нөхцөлд эвлэрүүлэн зуучлал дуусгавар болно:

а/талууд хоорондын маргаантай асуудлын аль нэг, эсхүл бүх асуудлыг хамарсан эвлэрлийн гэрээ байгуулснаар;

б/ хэдийд ч аль нэг талын бичгээр өгсөн мэдэгдлээр;

в/талуудын тохиролцсон, эсхүл холбогдох дүрмээр заасан өөр ямар нэг аргаар буюу зарим нөхцөл байдлаар.

2. Эвлэрүүлэн зуучлал дуусгавар болсон үед эвлэрүүлэн зуучлагч болон талууд эвлэрүүлэн зуучлал дууссан тухай, түүний дууссан огноо, маргаан шийдвэрлэгдсэн эсэх, хэрэв шийдвэрлэгдсэн бол бүрэн эсхүл хэсэгчлэн шийдвэрлэгдсэн эсэхийг Ерөнхий нарийн бичгийн даргад нэн даруй мэдэгдэнэ.



37 дугаар зүйл. Ажиллагааны зардал

1. Талууд Байгууллагын эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ, тоног төхөөрөмжийг ашигласны төлөө төлөх хураамжийг Удирдах зөвлөлийн баталсан дүрэм, журмын дагуу Ерөнхий нарийн бичгийн дарга тогтооно.
2. Эвлэрүүлэн зуучлагчийн хөлс, зардлыг Удирдах зөвлөл тухай бүр тооцоолсон хязгаарын хүрээнд тогтооно.
3. Талууд өөрөөр тохиролцоогүй бол эвлэрүүлэн зуучлагчийн хөлс, зардал, мөн Байгууллагын эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ, тоног төхөөрөмжийг ашигласны хураамжийг талууд тэнцүү хувааж төлнө. Тал бүр ажиллагаатай холбогдуулан бусад зардлаа өөрөө хариуцна.

38 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх бусад ажиллагаатай харилцах харилцаа

1. Бусад маргаан шийдвэрлэх ажиллагаа аль хэдий нь эхэлсэн эсэхээс үл хамааран, талууд хэдийд ч энэхүү Конвенцын дагуу эвлэрүүлэн зуучлалыг ашиглах боломжтой.
2. Хэрэв талууд тохиролцвол бусад маргаан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилсээр байх хооронд эвлэрүүлэн зуучлалыг үргэлжлүүлж болно.
3. Талууд холбогдох хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд, эвлэрүүлэн зуучлал эхэлсэн өдрөөс эхлэн дуусгавар болсон өдрийг хүртэлх хугацаанд, эвлэрүүлэн зуучлалын асуудал болсон маргаанд холбогдох хөөн хэлэлцэх хугацаа, эсхүл түүнтэй адилтгах дүрмийн хугацааг түр зогсоохоор тохиролцож болно.
4. Энэхүү Конвенцын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлал нь талуудад боломжтой бусад маргаан шийдвэрлэх механизмаар маргаанаа шийдвэрлэх эрхэд халдахгүй.



VII БҮЛЭГ

ЭВЛЭРЛИЙН ГЭРЭЭ

39 дүгээр зүйл. Эвлэрлийн гэрээ байгуулах

1. Талууд энэхүү Конвенцын дагуу эвлэрүүлэн зуучлалаар маргааныг бүхэлд нь буюу хэсэгчлэн шийдвэрлэх эвлэрлийн нөхцөлийг тохиролцсон бол цахим харилцааны хэлбэрийг оролцуулан бичгээр эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулсан эвлэрлийн гэрээ (цаашид “эвлэрлийн гэрээ” гэх) -д гарын үсэг зурна.
2. Талуудын гарын үсэг зурсан эвлэрлийн гэрээг талууд өөрөөр тохиролцоогүй бол уг гэрээ нь энэхүү Конвенцын дагуу эвлэрүүлэн зуучлалын үр дүнд бий болсныг нотлох зорилгоор Ерөнхий нарийн бичгийн дарга баталгаажуулна.

40 дүгээр зүйл. Эвлэрлийн гэрээний хуулийн хүчинтэй байдал

1. Маргааны талууд хооронд зохих журмаар байгуулсан аливаа эвлэрлийн гэрээ нь тэдгээрийн хувьд заавал биелүүлэх шинжтэй бөгөөд талууд гэрээг шударгаар биелүүлнэ.
2. Эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурснаар талууд уг гэрээг эвлэрүүлэн зуучлалын үр дүнд бий болсны нотолгоо болгон ашиглаж болно, мөн холбогдох хуулийн дагуу маргааныг шийдвэрлэсэнд санал нэгдсэн гэж үзнэ.
3. Эвлэрлийн гэрээнд аль нэг тал гарын үсэг зурснаар тухайн гэрээний нөхцөлийг тогтооход үндэслэл болсон хууль зүйн болон бодит нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрч байна гэж үзэхгүй.

41 дүгээр зүйл. Эвлэрлийн гэрээг биелүүлэх

1. 28 дугаар зүйлд заасны дагуу талууд олон улсын арилжааны маргааныг шийдвэрлэхээр байгуулсан эвлэрлийн гэрээг хэлэлцэн тохирогч улс өөрийн холбогдох хуулийн дагуу биелүүлэх арга хэмжээ авч болно.
2. Энэхүү Конвенцын 1 дэх хэсэгт заасан эвлэрлийн гэрээг хэлэлцэн тохирогч улс ямар нөхцөлөөр биелүүлэх тухайгаа тодорхойлох Протоколыг хэлэлцэн тохирогч улсууд тохиролцоно. Ийм Протокол нь энэхүү Конвенцын 56 дугаар зүйлд заасны дагуу Конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулахад шаардлагатай адил журмаар батлагдаж, хүчин төгөлдөр болно.



VIII БҮЛЭГ

ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

42 дүгээр зүйл. Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа

1. Байгууллага нь нөөц боломжийнхоо хүрээнд чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
2. Чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Байгууллага нь засгийн газар, олон улсын байгууллага, эсхүл бусад этгээдүүдтэй зохицуулалт хийж, хамтран ажиллаж болно.
3. Нарийн бичгийн дарга нарын газар нь чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор жил бүр ажлын төлөвлөгөө бэлтгэн, Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулна.
4. Нарийн бичгийн дарга нарын газар нь Удирдах зөвлөлийн зөвшөөрлөөр залуу мэргэжилтнүүд, дипломат ажилтнуудыг сургах, чадавх бэхжүүлэх зорилготой эвлэрүүлэн зуучлалын тэтгэлэгт хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж болно.

43 дугаар зүйл. Чадавх бэхжүүлэх хороо

1. Чадавх бэхжүүлэх хороог байгуулах бөгөөд уг хороо нь Удирдах зөвлөлийн ерөнхий удирдлага дор, Нарийн бичгийн дарга нарын газраас захиргааны шинжтэй дэмжлэг үзүүлэн ажиллана.
2. Хорооны үүрэг нь чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны стратеги, тэргүүлэх чиглэлийн талаар Удирдах зөвлөлд зөвлөмж өгөхөд оршино.

44 дүгээр зүйл. Эвлэрүүлэн зуучлалын сан

Энэхүү Конвенцын зорилгоор эвлэрүүлэн зуучлалын хэрэглээг дэмжих, урамшуулах, чадавх бэхжүүлэх ажлыг сайжруулах зорилгоор Эвлэрүүлэн зуучлалын сан байгуулж болно. Уг сан нь хандиваас бүрдэх бөгөөд Удирдах зөвлөлийн баталсан санхүүгийн дүрэм, журмын дагуу түүнийг удирдана.



IX БҮЛЭГ

САНХҮҮЖИЛТ

45 дугаар зүйл. Санхүүгийн журам

Байгууллагатай холбоотой санхүүгийн бүх асуудлыг энэхүү Конвенц, мөн Удирдах зөвлөлийн баталсан санхүүгийн дүрэм, журмаар зохицуулна.

46 дугаар зүйл. Санхүүгийн эх үүсвэр

1. Нарийн бичгийн дарга нарын газар өөрийн эрх үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрээр хангагдсан байна.
2. Байгууллагын үндсэн санхүүгийн эх үүсвэрт хэлэлцэн тохирогч улсуудын жилийн хураамж, мөн Байгууллагын орлого орно.
3. Өмнөх хэсэгтэй зөрчилдөхгүйгээр, Байгууллага нь Удирдах зөвлөлийн баталсан санхүүгийн дүрэм журмын дагуу засгийн газар, олон улсын байгууллага, хувь хүн, корпорац, бусад этгээдээс ирсэн сайн дурын хандивыг нэмэлт санхүүгийн эх үүсвэр болгон хүлээн авч, ашиглаж болно. Гэхдээ Байгууллага нь өөрийн зорилго, үүрэгт ямар нэгэн байдлаар хохирол учруулах, хязгаарлах, чиглэлийг нь өөрчлөх, эсхүл өөрөөр өөрчилж болзошгүй аливаа хандив, тусламжийг хүлээн авахгүй.

47 дугаар зүйл. Шимтгэлийн хэмжээг тогтоох

Хэлэлцэн тохирогч улсуудын жилийн хураамжийг Дэлхийн шуудангийн холбооны хураамжийн дагуу тогтооно. Мөн хэлэлцэн тохирогч улсуудын эдийн засгийн хөгжлийн түвшин, төлөх чадварыг харгалзан үзэж болно.



Х БҮЛЭГ

ДАРХАН ЭРХ, ЯМБА

48 дугаар зүйл. Ерөнхий зарчим


1. Байгууллага нь хэлэлцэн тохирогч улсуудын нутаг дэвсгэрт өөрийн зорилго, үүргийг хэрэгжүүлэх, биелүүлэхэд шаардлагатай дархан эрх, ямбыг эдэлнэ.
2. Хэлэлцэн тохирогч улсуудын төлөөлөгчид болон Байгууллагын албан тушаалтнууд нь Байгууллагатай холбоотой чиг үүргээ бие даан хэрэгжүүлэхэд шаардлагатай дархан эрх, ямбыг адил эдэлнэ.

49 дүгээр зүйл. Өмч хөрөнгө, сан хөрөнгө, хөрөнгө

1. Байгууллага, түүний өмч хөрөнгө, ашиг сонирхол нь хаана байрлаж, хэнд хамаарахаас үл хамааран, аль нэг тодорхой хэргийн хувьд Байгууллага дархан эрхээ тодорхой хэмжээгээр хүчингүй болгохоо илэрхийлснээс бусад тохиолдолд аливаа төрлийн шүүхийн ажиллагаанаас чөлөөлөгдөх дархан эрхийг эдэлнэ. Байгууллагад өгсөн аливаа дархан эрхээс татгалзах нь шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаанаас эдлэх дархан эрхэд хамаарахгүй бөгөөд уг дархан эрхээс Байгууллага тусгайлан, илэрхий байдлаар тусад нь татгалзсан тохиолдолд л хүчинтэйд тооцно.
2. Байгууллагын байгууламж халдашгүй байна. Байгууллагын өмч хөрөнгө, ашиг сонирхол нь хаана байрлаж, хэн эзэмшихээс үл хамааран, гүйцэтгэх, захиргааны, шүүх, хууль тогтоомжийн аль ч үйл ажиллагаагаар нэгжлэг хийх, дайчлах, албадан хураан авах, өөрчлөн авах, эсхүл бусад хэлбэрээр хөндлөнгөөс оролцохгүй.
3. Байгууллагын архивын материалууд, Байгууллагад хамаарах буюу эзэмшилд байгаа бүх баримт бичиг халдашгүй байна.
4. Ямар ч төрлийн санхүүгийн хяналт, журам, эсхүл төлбөрийг түр хойшлуулахгүйгээр:

а/Байгууллага ямар ч төрлийн хөрөнгө, мөнгөн тэмдэгт, бусад хөрөнгийг эзэмших, мөн ямар ч хөрвөх боломжтой валютаар данс нээх, ашиглах эрхтэй;

б/Байгууллага өөрийн хөрөнгө, мөнгөн тэмдэгт, бусад хөрөнгийг нэг улсаас нөгөө улс руу, эсхүл ямар ч улсын дотор чөлөөтэй шилжүүлэх, мөн өөрийн эзэмшил дэх аль ч мөнгөн тэмдэгтийг өөр ямар ч мөнгөн тэмдэгт болгон хөрвүүлэх эрхтэй.



5. Байгууллага, түүний хөрөнгө, орлого, бусад өмч нь:

а/бүх шууд татвараас чөлөөлөгдөнө; Гэхдээ нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөрийн шинжтэй татвар, хураамжийн хувьд Байгууллага татвараас чөлөөлөгдөх эрх эдлэхгүй.

б/ Байгууллагын албан хэрэгцээнд зориулан импортолсон, экспортолсон бараа бүтээгдэхүүнд гаалийн татвар, импорт, экспортын хориг, хязгаарлалт тавихгүй. Гэхдээ ийм чөлөөлөлтөөр импортолсон барааг тухайн улсын засгийн газартай тохиролцсон нөхцөлөөс бусад тохиолдолд импортолсон улсад худалдан борлуулахгүй;

в/ Байгууллагын хэвлэл, нийтлэлд хамаарах импорт, экспортын үйл ажиллагааны хувьд гаалийн татвар, мөн импорт, экспортод тавих аливаа хориглолт, хязгаарлалтаас чөлөөлөгдөнө.

6. Байгууллага ерөнхий дүрэм журмын дагуу онцгой албан татвар болон төлөх үнийн дүнгийн нэг хэсэг болох хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын татвараас чөлөөлөгдөхгүй. Гэвч Байгууллага албан ёсны хэрэгцээнд зориулж чухал шаардлагатай худалдан авалт хийх тохиолдолд хэлэлцэн тохирогч улсууд татварын дүнг буцаан олгох, эсхүл буцаах зорилгоор боломжтой бол зохих захиргааны зохицуулалтыг хийнэ.


50 дугаар зүйл. Харилцаа холбооны талаарх дэмжлэг

Хэлэлцэн тохирогч улс бүр Байгууллагын албан ёсны харилцаа холбоонд бусад улсын албан ёсны харилцаа холбоонд үзүүлж буйтай адил нөхцөл үзүүлнэ.

51 дүгээр зүйл. Хэлэлцэн тохирогч улсуудын төлөөлөгчид

1. Удирдах зөвлөл болон Байгууллагын зарласан уулзалтад оролцож буй хэлэлцэн тохирогч улсуудын төлөөлөгчид чиг үүргээ хэрэгжүүлж байх үедээ, мөн хуралдааны газар луу явах, буцах аяллын үеэр дараах дархан эрх, ямбыг эдэлнэ:

а/биечлэн баривчлах, саатуулах, хувийн ачаа тээшийг хураахгүй байх; мөн тэдний төлөөлөгчийн хувиар хэлсэн, бичсэн үг, хийсэн бүх үйлдлийн хувьд бүх төрлийн шүүхийн ажиллагаанаас чөлөөлөгдөх;



б/бүх бичиг, баримт хамгаалагдах;

в/код хэрэглэх, бичиг баримт буюу захидлыг холбоо эсхүл битүүмжилсэн шуудангаар хүлээн авах эрх;


г/өөрсдөө болон эхнэр, нөхөр нь чиг үүргээ хэрэгжүүлэхээр очиж буй, эсхүл дамжин өнгөрч буй хэлэлцэн тохирогч улсын цагаачлалын хязгаарлалт, гадаадын иргэний бүртгэл, эсхүл цэргийн алба хаах үүргээс чөлөөлөгдөх;

д/гадаадын засгийн газрын түр албан ёсны төлөөлөгчдөд олгодогтой адил валют, валютын хязгаарлалтын талаарх дэмжлэг;

е/ хувийн ачаа тээшний талаар дипломат төлөөлөгчдөд олгодогтой ижил дархан эрх, ямба;

ж/дээрхтэй нийцэхүйц, дипломат төлөөлөгчдийн эдэлдэг бусад дархан эрх, ямба, дэмжлэг; гэхдээ тэд импортын барааг (хувийн ачаа тээшний нэг хэсэг биш) гаалийн татвараас, эсхүл онцгой албан татвар, борлуулалтын татвараас чөлөөлөгдөх эрхгүй.

2. Удирдах зөвлөл болон Байгууллагын зарласан уулзалтад оролцож буй хэлэлцэн тохирогч улсуудын төлөөлөгчдийн үг хэлэх эрх чөлөө, чиг үүргээ гүйцэтгэх бие даасан байдлыг хангах зорилгоор, тэдний чиг үүргээ гүйцэтгэхдээ хэлсэн, бичсэн үг, хийсэн бүх үйлдэл шүүхийн ажиллагаанаас чөлөөлөгдөх бөгөөд холбогдох хүмүүс хэлэлцэн тохирогч улсын төлөөлөгч байхаа больсон ч гэсэн энэ чөлөөлөлт үйлчилнэ.
3. Аливаа татварын хэлбэр нь оршин суух хугацаанаас хамаардаг бол, Удирдах зөвлөл болон Байгууллагын зарласан уулзалтад оролцож буй хэлэлцэн тохирогч улсуудын төлөөлөгчид чиг үүргээ гүйцэтгэхдээ хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрт байсан хугацааг оршин суух хугацаа гэж тооцохгүй.
4. Дархан эрх, ямбыг хэлэлцэн тохирогч улсуудын төлөөлөгчдөд хувь хүмүүсийн хувийн ашиг сонирхолд зориулж бус, харин Байгууллагатай холбоотой чиг үүргээ бие даан хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах зорилгоор олгоно. Иймээс хэлэлцэн тохирогч улс нь дархан эрх нь шударга ёсыг хэрэгжүүлэхэд саад болж, мөн дархан эрх олгосон зорилгод хохирол учруулахгүйгээр татгалзаж болох тохиолдолд, өөрийн төлөөлөгчийн дархан эрхээс татгалзах үүрэгтэй.
5. Энэ зүйлийн 1-3 дахь хэсэгт заасан дархан эрх, ямба нь төлөөлөгч болон түүний иргэншилтэй Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагуудын хооронд, түүнчлэн төлөөлөгчийн төлөөлж буй эсхүл өмнө нь төлөөлж байсан Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагуудтай холбоотой харилцаанд үйлчлэхгүй.



6. Энэ зүйлд дурдсан “төлөөлөгчид” гэх ойлголтод төлөөлөгчид, орлогч төлөөлөгчид, зөвлөхүүд, техникийн шинжээчид болон төлөөлөгчдийн бүрэлдэхүүний нарийн бичгийн дарга нар бүгд хамаарна.

52 дугаар зүйл. Албан тушаалтнууд

1. Ерөнхий нарийн бичгийн дарга энэ зүйлийн заалтыг хэрэглэх албан тушаалтнуудын ангиллыг тогтоож, түүнийг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулна. Батлагдсаны дараа эдгээр ангиллыг бүх Хэлэлцэн тохирогч улсын Засгийн газарт мэдэгдэнэ. Мөн дээрх ангилалд хамрагдах албан тушаалтнуудын нэрсийг тухай бүр Хэлэлцэн тохирогч улсуудын Засгийн газарт хүргүүлж байна.

2. Байгууллагын албан тушаалтнууд нь:

а/албан тушаалтны хувьд хэлсэн, бичсэн үг, хийсэн үйлдлийнх нь хувьд шүүхийн ажиллагаанаас чөлөөлөгдөнө;

б/Байгууллагаас авсан цалин, нэмэгдэлд татвараас чөлөөлөгдөх;

в/өөрөө болон эхнэр, нөхөр, тэднээс хамааралтай төрөл төрөгсөд нь цагаачлалын хязгаарлалт, гадаадын иргэний бүртгэлээс чөлөөлөгдөх;

г/валютын хязгаарлалтын талаар гадаадын засгийн газрын албан ёсны төлөөлөгчид олгодогтой ижил дэмжлэг авах;

д/нутаг дэвсгэрт нь байрлаж буй дипломат төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтах гуравдагч этгээдэд олгодогтой ижил аяллын дэмжлэг;

е/олон улсын хямралын үед эхнэр, нөхөр, тэднээс хамааралтай төрөл төрөгсдийн хамт дипломат төлөөлөгчдөд олгодогтой ижил нутаг буцаах дэмжлэг үзүүлэх;

ж/тухайн улсад анх удаа албан тушаалдаа орохдоо тавилга, эд хогшлоо татваргүйгээр импортлох.

3. Ерөнхий нарийн бичгийн дарга, аливаа Дэд ерөнхий нарийн бичгийн дарга нар нь өөрсдөд нь мөн эхнэр, нөхөр, насанд хүрээгүй хүүхдүүдэд нь олон улсын эрх зүйн дагуу дипломат төлөөлөгчдөд олгодог дархан эрх, ямба, чөлөөлөлт, дэмжлэгийг 2 дахь хэсэгт заасан дархан эрх, ямбанаас гадна нэмж олгоно.



4. Дархан эрх, ямбыг албан тушаалтнуудад хувь хүмүүсийн хувийн ашиг сонирхолд бус, харин Байгууллагын ашиг сонирхолд зориулж олгоно. Ерөнхий нарийн бичгийн дарга нь өөрийн үзэмжээр дархан эрх нь шударга ёсыг хэрэгжүүлэхэд саад болж, мөн Байгууллагын ашиг сонирхолд хохирол учруулахгүйгээр татгалзаж болох тохиолдолд, аливаа албан тушаалтны дархан эрхийг татгалзах эрх, үүрэгтэй. Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд Удирдах зөвлөл дархан эрхийг татгалзах эрхтэй.
5. Байгууллага нь шударга ёсыг зохистой хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нийтийн аюулгүй байдал, дэг журмын хууль, дүрмийг дагаж мөрдөхийг хангах, мөн энэ зүйлд дурдсан дархан эрх, ямба, дэмжлэгтэй холбогдуулан гарч болох аливаа хууль бус ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэлэлцэн тохирогч улсуудын холбогдох байгууллагатай байнга хамтран ажиллана.

53 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлагч болон эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогчид

1. 25, 27 дугаар зүйлд заасан маргааны дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд эвлэрүүлэн зуучлагч, тал, төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээчээр оролцож буй хүмүүст дараах дархан эрх, ямбыг олгоно:

а/чиг үүргээ хэрэгжүүлж байх хугацаанд биечлэн баривчлах, саатуулах, хувийн ачаа тээшийг хураах;

б/эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцсон үедээ хэлсэн, бичсэн үг, хийсэн бүх үйлдлийнх нь хувьд шүүхийн ажиллагаанаас чөлөөлөх;

в/ эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцсонтой холбоотой бүх бичиг баримт, ямар ч хэлбэрийн баримт бичиг, материалыг хамгаалах;

г/эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай холбоотой харилцааны зорилгоор зохих ёсоор тодорхойлогдсон холбоо буюу битүүмжилсэн шуудангаар ямар ч хэлбэрийн бичиг, баримтыг хүлээн авах, илгээх эрх;

д/тухайн улсын харьяат иргэн биш бол, хэлэлцэн тохирогч улсууд Байгууллагын албан тушаалтнуудад олгодогтой адил цагаачлалын хязгаарлалт, гадаадын иргэний бүртгэлийн шаардлага, цэргийн алба хаах үүргээс чөлөөлөгдөх, валютын хязгаарлалт, аяллын дэмжлэгийн талаарх ижил нөхцөлийг эдлэх.

е/ болон д/-д заасан дархан эрх нь зөвхөн ажиллагаа явагдаж буй газар луу явах, буцах аялал, мөн тэнд байх хугацаанд хамаарна.

2. Энэхүү Конвенцын дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд эвлэрүүлэн зуучлагчаар оролцож буй хүмүүс Байгууллагаас эсхүл Байгууллагаар



дамжуулан тэдний эвлэрүүлэн зуучлагчийн хувиар хийсэн ажилд олгох аливаа хөлс, зардлын нөхөн олговор татвараас чөлөөлөгдөнө.

3. Дархан эрх, ямбыг дурдсан хүмүүст хувь хүмүүсийн хувийн ашиг сонирхолд бус, харин Байгууллагын ашиг сонирхолд зориулж олгодог. Байгууллага нь өөрийн үзэж байгаагаар дархан эрх нь шударга ёсыг хэрэгжүүлэхэд саад болж, мөн Байгууллагын ашиг сонирхолд хохирол учруулахгүйгээр татгалзаж болох тохиолдолд, аливаа хүний дархан эрхийг татгалзах эрх, үүрэгтэй.

54 дүгээр зүйл. Дархан эрх үл хамаарах нөхцөл

51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн а/ заалт, 52 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн а/ заалт, 53 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн б/ заалтад тус тус заасан дархан эрх нь зам тээврийн ослоос үүдэн учирсан хохирол, эсхүл бусад төрлийн бие махбодын гэмтэл, нас баралтаас үүсэх иргэний эрх зүйн хариуцлагад үл хамаарна.

ХІ БҮЛЭГ

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

55 дугаар зүйл. Энэхүү Конвенцыг тайлбарлах буюу хэрэглэхтэй холбоотой санал зөрөлдөөнийг шийдвэрлэх

Энэ Конвенцын тайлбар болон хэрэгжилттэй холбоотой аливаа санал зөрөлдөөн нь хэлэлцээний замаар шийдвэрлэгдэхгүй тохиолдолд, холбогдох Хэлэлцэн тохирогч улсын хүсэлтээр Удирдах зөвлөлд зөвлөмж гаргуулахаар шилжүүлнэ.

56 дугаар зүйл. Нэмэлт, өөрчлөлт оруулах

1. Аливаа хэлэлцэн тохирогч улс энэхүү Конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа Ерөнхий нарийн бичгийн даргад ирүүлж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга уг саналыг нэн даруй хэлэлцэн тохирогч улсуудад мэдэгдэнэ.
2. Энэхүү Конвенцод оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн тохирогч улсууд аль болох нийтийн зөвшилцлийн үндсэн дээр батлах ёстой. Бүх боломжит арга хэмжээг авсан ч зөвшилцөлд хүрч чадахгүй бол нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн тохирогч улсуудын гуравны хоёрын олонхын саналаар батална.
3. 2 дахь хэсэгт заасны дагуу батлагдсан нэмэлт, өөрчлөлт нь хэлэлцэн тохирогч улсуудын соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах шаардлагад хамаарна.



4. 2 дахь хэсгийн дагуу батлагдсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсхүл батлах тухай гурав дахь баримт бичгийг хадгалуулснаас хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно. Ийнхүү хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлт нь түүнд заавал дагаж мөрдөхийг зөвшөөрсөн Хэлэлцэн тохирогч улсуудын хувьд заавал биелэгдэх шинжтэй байна. Бусад Хэлэлцэн тохирогч улсуудын хувьд энэ Конвенцын заалт болон тэдгээрийн соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн эсхүл баталгаажуулсан өмнөх нэмэлт, өөрчлөлтүүд хүчинтэй хэвээр байна.
5. Гурав дахь соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсхүл батлах баримт бичиг хадгалуулсны дараа Хэлэлцэн тохирогч улс аливаа нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсхүл батлах үед тухайн нэмэлт, өөрчлөлт нь уг Хэлэлцэн тохирогч улсын хувьд түүний соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсхүл батлах баримт бичгийг хадгалуулснаас хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно.
6. Ямар ч нэмэлт, өөрчлөлт нь нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос өмнө энэхүү Конвенцын дагуу эвлэрүүлэн зуучлалд өгсөн зөвшөөрлөөс үүдэн гарсан маргааны аль нэг талын эрх, үүрэгт нөлөөлөхгүй.

57 дугаар зүйл. Нэгдмэл бус эрх зүйн тогтолцоотой холбоотой мэдэгдэл

1. Хэрэв аливаа улс нь хоёр буюу түүнээс дээш нутаг дэвсгэрийн нэгжтэй бөгөөд энэхүү Конвенцод зохицуулагдаж буй асуудлуудтай холбоотойгоор өөр өөр эрх зүйн тогтолцоо үйлчилдэг бол тэр улс гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох үедээ энэхүү Конвенц нь түүний бүх нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах, эсхүл зөвхөн нэг буюу хэд хэдэн нь хамаарах тухай мэдэгдэл хийж болох бөгөөд хэдийд ч өөр мэдэгдэл ирүүлснээр энэхүү мэдэгдлээ өөрчилж болно.
2. Мэдэгдлийг гэрээ хадгалагчид хүргүүлэх бөгөөд энэхүү Конвенцын үйлчлэх нутаг дэвсгэрийн нэгжүүдийг тодорхой заасан байна.
3. Хэрэв улс хоёр буюу түүнээс дээш нутаг дэвсгэрийн нэгжтэй бөгөөд энэхүү Конвенцод зохицуулагдаж буй асуудлуудтай холбоотойгоор өөр өөр эрх зүйн тогтолцоо үйлчилдэг бол:
 - а/ аливаа улсын хууль тогтоомж эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын тухай эшлэлийг, шаардлагатай тохиолдолд, тухайн холбогдох нутаг дэвсгэрийн нэгжид хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг хэлж буйгаар ойлгоно.



6/28 дугаар зүйлд заасан маргаан гэдэгт тухайн улсын өөр өөр нутаг дэвсгэрийн нэгж дэх талуудын хоорондын арилжааны харилцаанаас үүдэн гарсан буюу түүнтэй холбоотой маргааныг багтаана гэж тайлбарлана.

4. Хэрэв улс энэ зүйлийн дагуу мэдэгдэл хийгээгүй бол энэхүү Конвенц нь тухайн улсын бүх нутаг дэвсгэрийн нэгжид хамаарна.
5. Энэ зүйл нь бүс нутгийн интеграцийн байгууллагад хамаарахгүй.

58 дугаар зүйл. Бүс нутгийн интеграцийн байгууллагын оролцоо

1. Бүрэн эрхт улсуудаас бүрдсэн, энэхүү Конвенцод зохицуулагдаж буй зарим асуудалд эрх мэдэл бүхий бүс нутгийн интеграцийн байгууллага нь энэхүү Конвенцод гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох боломжтой. Энэ тохиолдолд бүс нутгийн интеграцийн байгууллага нь уг байгууллага энэхүү Конвенцоор зохицуулагдаж буй асуудалд эрх мэдэлтэй болох хэмжээнд хэлэлцэн тохирогч улсын эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Уг эрх мэдлийн хүрээг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох баримт бичигт тунхагласан байна. Хожим ийм байгууллага нь эрх мэдлийн хүрээнд гарсан аливаа үндсэн өөрчлөлтийн талаар гэрээ хадгалагчид мэдэгдэнэ.
2. Энэ Конвенцод “Хэлэлцэн тохирогч улс” эсхүл “Хэлэлцэн тохирогч улсууд” гэж дурдсан нь тухайн байгууллагын эрх хэмжээний хязгаарын хүрээнд уг байгууллагад нэгэн адил хамаарна.
3. 56 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зорилгоор бүс нутгийн интеграцийн байгууллагын хадгалуулсан аливаа баримт бичгийг тухайн байгууллагын гишүүн улсуудын хадгалуулсан баримт бичгүүдэд нэмэлтээр тооцохгүй.
4. Бүс нутгийн интеграцийн байгууллага нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хамаарах асуудлаар Удирдах зөвлөлд санал өгөх эрхээ хэрэгжүүлж болох бөгөөд саналын тоо нь тус байгууллагын гишүүн бөгөөд энэхүү Конвенцод оролцогч улсуудын тоотой тэнцүү байна. Хэрэв тухайн байгууллагын аль нэг гишүүн улс санал өгөх эрхээ хэрэгжүүлж байгаа бол тус байгууллага санал өгөх эрхээ хэрэгжүүлэхгүй, мөн эсрэгээр.



59 дүгээр зүйл. Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох

1. Энэхүү Конвенц нь 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Бүгд Найрамдах Хятад Ард Улсын засаг захиргааны онцгой бүс Хонконг хотноо бүх улс болон бүс нутгийн интеграцийн байгууллагууд гарын үсэг зурахад нээлттэй байна. Үүний дараа Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш гурван жил хүртэл хугацаанд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гадаад хэргийн яаманд Бээжин хотод гарын үсэг зурахад нээлттэй хэвээр байх болно.
2. Энэхүү Конвенцыг гарын үсэг зурсан улс болон бүс нутгийн интеграцийн байгууллагууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батална.
3. Энэхүү Конвенц нь гарын үсэг зурахад нээлттэй болсон өдрөөс эхлэн гарын үсэг зураагүй бүх улс болон бүс нутгийн интеграцийн байгууллагууд нэгдэн ороход нээлттэй байна.
4. Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох баримт бичгийг гэрээ хадгалагчид хадгалуулна.

60 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү Конвенц нь соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох гурав дахь баримт бичгийг хадгалуулснаас хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно.
2. Гурав дахь баримт бичгийг хадгалуулсны дараа энэхүү Конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл түүнд нэгдэн орж буй улс, эсхүл бүс нутгийн интеграцийн байгууллага бүрийн хувьд Конвенц нь тухайн улс, эсхүл бүс нутгийн интеграцийн байгууллага соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох баримт бичгээ хадгалуулснаас хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно.

61 дүгээр зүйл. Татгалзах

1. Хэлэлцэн тохирогч улс гэрээ хадгалагчид бичгээр мэдэгдэж, энэхүү Конвенцоос татгалзаж болно. Татгалзах нь энэхүү Конвенцыг+ үйлчлэх нэгдмэл бус эрх зүйн тогтолцооны зарим нутаг дэвсгэрийн нэгжид хязгаарлагдаж болно.
- 2.



3. Татгалзах нь мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болох бөгөөд хэрэв мэдэгдэлд тусгай өдрийг заасан бол тэр өдрөөс хүчин төгөлдөр болно.
4. Хэлэлцэн тохирогч улсын энэ зүйлд заасны дагуу гаргасан мэдэгдэл нь гэрээ хадгалагч мэдэгдлийг хүлээн авахаас өмнө энэхүү Конвенцын дагуу эвлэрүүлэн зуучлалд өгсөн зөвшөөрлөөс үүдэн гарсан маргааны аль нэг талын эрх, үүрэгт нөлөөлөхгүй.

62 дугаар зүйл. Гэрээ хадгалагч

1. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар энэхүү Конвенцын гэрээ хадгалагч болно.
2. Гэрээ хадгалагч нь бүх Хэлэлцэн тохирогч улсууд, бусад гарын үсэг зурсан талууд болон Ерөнхий нарийн бичгийн даргад дараах мэдээллийг тухайлан мэдэгдэнэ:
 - а/56, 58, 59 дүгээр зүйлд заасан гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох тухай;
 - б/энэхүү Конвенцын 60 дугаар зүйлийн дагуу хүчин төгөлдөр болсон огноо;
 - в/энэхүү Конвенцын нэмэлт, өөрчлөлт 56 дугаар зүйлийн дагуу хүчин төгөлдөр болсон огноо;
 - г/25, 29, 57, 58 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тунхаглал;
 - д/ 61 дүгээр зүйлд заасан татгалзсан үйл ажиллагаа.

63 дугаар зүйл. Эх бичвэрүүд

Араб, хятад, англи, франц, орос, испани хэл дээрх эх бичвэрүүд адил хүчинтэй. Энэхүү Конвенцын эхийг гэрээ хадгалагчид хадгалуулах бөгөөд гэрээ хадгалагч түүний гэрчлэгдсэн хуулбарыг бүх хэлэлцэн тохирогч улсуудад илгээнэ.



ҮҮНИЙГ НОТОЛЖ ДООР гарын үсэг зурсан хүмүүс өөр өөрсдийн
Засгийн газраас зохих ёсоор эрх олгогдсоны үндсэн дээр энэхүү Конвенцод
гарын үсэг зурав.

2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын
засаг захиргааны онцгой бүс Хонконгд ҮЙЛДЭВ.

